

**Олон улсын хөрөнгө оруулалтын эрх зүйн
түүх, хөгжлийн чиг хандлага**

**History and Development Tendency
of International Investment Law**

Энх-Амгалангийн Байгал

Хууль зүйн ухааны доктор (Ph.D.).

Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн

Хувийн эрх зүйн тэнхимийн дэд профессор

Улаанбаатар хот, Монгол Улс

baigal_e@num.edu.mn

© E.Baigal, 2025



[Attribution-NonCommercial 4.0 International
\(CC BY-NC 4.0\)](https://creativecommons.org/licenses/by-nc/4.0/)

[Товч утга]

2000 оны үеэс эхлэн огцом хөгжиж буй нэгэн салбар эрх зүй бол олон улсын хөрөнгө оруулалтын эрх зүй юм. Эрдэмтэн судлаачдын бүтээлд, олон улсын хөрөнгө оруулалтын эрх зүйг гол төлөв эртний-дундад зууны үе, колоничлолын өмнөх ба дараахь үе хэмээн хувааж авч үздэг ч энэхүү ангиллыг өөрчлөх хугацаа нэгэнт иржээ. Бидний мэдэхээр, колоничлолын өмнөх үе, эсхүл дэлхийн 2-р дайны өмнөх ба дараах гэж ангилж байсан үеэс хойш, социалист систем нуран унасан-глобальчлалын үе гэж нэрлэх үе, түүний дараа олон улсын хөрөнгө оруулалтын эрх зүйн шинэтгэлийн үе 2010-аад оноос эхлэн явагдаж байна. Энэхүү өгүүлэлдээ олон улсын хөрөнгө оруулалтын эрх зүйн түүхийн өмнө тогтсон уламжлалт ангиллыг шинэчлэн, өөрийн санал дүгнэлтийг боловсруулан толилуульж байна.

[Түлхүүр үг]

Хөрөнгө оруулалтын эрх зүй, Олон улсын хөрөнгө оруулалтын эрх зүй, Хөрөнгө оруулалтыг хамгаалах хэлэлцээр, хөрөнгө оруулалтын эрх зүйн түүхэн хөгжил, олон улсын хөрөнгө оруулалтын эрх зүйн хөгжлийн чиг хандлага.

I. Удиртгал

Олон улсын эдийн засгийн эрх зүйн хамгийн залуу бөгөөд эрчимтэй хөгжиж буй салбар бол олон улсын хөрөнгө оруулалтын эрх зүй юм. Хэдийгээр үүсэл хөгжлийн хувьд эртний Ромын үеэс эхлэн гадаадын иргэний эд хөрөнгийн асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар зарим нэг үзэл баримтлал байсан боловч, өнөөгийн хөгжлийн гол суурь нь 1950-иад оноос эхтэй гэж үздэг. Хэдий богино хугацаанд хөгжиж байгаа ч хэд хэдэн үе шатыг дамжиж, нэн ялангуяа сүүлийн жилүүдэд эрх зүйн зохицуулалтын чиг хандлага нь огцом өөрчлөгдөж буйгаас үүдэн, энэхүү сэдвээр судалгаа хийхийг зорьсон юм. Энд, эртний үе болон колоничлолын үед гадаадын иргэд аж ахуй эрхлэх, тэдний хөрөнгийг хэрхэн хамгаалж байсан, Дэлхийн 2 дугаар дайнаас хойш олон улсын эрх зүйн зохицуулалт хэрхэн өөрчлөгдөж, эдүгээ ямар чиг хандлагыг баримталж эхэлж буйг түүхэн сурвалж болон олон улсын гэрээ хэлэлцээрийн үндсэн дээр судлан үзэж хөгжлийн үечлэлийг шинээр тодорхойлохыг оролдлоо.

Гадаадын хөрөнгө оруулалт буюу гадаадын иргэний өмчийг хамгаалах тухай асуудал нь эрт дээр үеэс улбаатайг судлаач Andrew Newcombe, Lluís Paradell, *Law and Practice of Investment Treaties* бүтээлдээ тодорхой дурьдсан байдаг ч бусад салбар эрх зүйтэй харьцуулахад төдийлөн дэлгэрэнгүй түүх байхгүй гэж хэлж болно.¹ Профессор М. Сорнаража нь “Гадаадын хөрөнгө оруулалтын олон улсын эрх зүй” бүтээлдээ хөрөнгө оруулалтын эрх зүйн түүхэн хөгжлийг колоничлолын үе ба колоничлолын дараах үе хэмээн хуваан авч үзсэн² бол хөрөнгө оруулалтын маргааныг арбитрт харьяалах гол үндэслэл болох хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай хэлэлцээрийг Кеннет Ж. Вандэвелде нь “Хоёр талт хөрөнгө оруулалтын хэлэлцээр-түүх, бодлого, тайлбар” хэмээх бүтээлдээ а/ колоничлолын үе-1820-1914 он, 1914-1944 он, б/ Хүйтэн дайны эрин:1944-1989 он, в/ Глобальчлалын үе: 1990- өнөө үе хэмээн ангилжээ.

Сүүлийн жилүүдэд олон улсын хөрөнгө оруулалтын эрх зүйд зарим нэг томоохон өөрчлөлт, шинэчлэлт хийгдэж байгаа бөгөөд энэ нь нэн ялангуяа маргаан шийдвэрлэх эрх зүйн зохицуулалтын хувьд түлхүү ажиглагдаж байна. НҮБ-ын Худалдаа хөгжлийн бага хурлаас хийж нийтэд толилуулсан зарим судалгаанд үндэслэн дээрх хөгжлийн үечлэл нь дараахь байдлаар шинэчлэгдэх нь зүйтэй гэж үзэж байна.

¹ Andrew Newcombe, Lluís Paradell, *Law and Practice of Investment Treaties*, (Kluwer Law International, 2009), 3.

² Muthucumarawamay Sornarajah, *The International law on foreign investment*, (Cambridge, 2010), 19-28.

Ийнхүү хөгжлийн үечлэлийг шинэчлэн болсон шалтгаан нөхцөл, шалгуур нь Хөрөнгө оруулалтыг хамгаалах засгийн газар хоорондын хэлэлцээрийн хөгжилтэй шууд хамааралтай гэж хэлж болох бөгөөд 2010 онд хүртэлх болон түүнээс хойш байгуулагдсан хэлэлцээрүүд дэх хөрөнгө оруулалтын маргаан шийдвэрлэх зохицуулалт, түүнчлэн 2015 оноос хойш байгуулагдаж буй хэлэлцээрүүдийн онцлог зохицуулалт, чиг хандлагад үндэслэсэн болно.

II. Эртний ба дундад зууны үе

Эртний үе буюу колоничлол эхлэхээс өмнөх үед, эртний Ромын хот улсуудад гадаадын хөрөнгө оруулалт, түүнийг хамгаалах тухай тусгайлсан эрх зүйн зохицуулалт байгаагүй гэдгийг судлаачид дийлэнх нь тэмдэглэсэн байдаг. Гэхдээ хот улсууд нь нөгөө хот улсын иргэний эрхийг хамгаалах эсэх, өөрөөр хэлбэл *alius* буюу бусад этгээд гэж нэрлэгдэх иргэдийн эрхийг хэрхэх тухай хуульчид үзэл бодлоо дэвшүүлдэг байжээ. Үнэндээ өөр хот улсын иргэд нь эрх зүйн чадваргүй гэж тооцогддог үе байв.³ Харин дундад зуунаас хойш гадаадын иргэдийн эрх зүйн байдал, түүний өмчийг хамгаалах талаархи үзэл бодол, эрх зүйн зохицуулалт хөгжиж эхэлсэн юм.⁴ Гуго Гроциа нь “хот улсын иргэнд хамаарах зүйлс” хэмээх ангилалд гадаадын иргэдийг авч үзсэн тухай тэмдэгдэгджээ. Гэхдээ Эммерих де Ваттел нь гадаадын иргэдийн эрх зүйн байдлын талаарх орчин үеийн эрх зүйн зохицуулалтын үндсийг тавьсан гэж үздэг ба 1758 онд хэвлүүлсэн *Law of Nations* бүтээлдээ аливаа улс нь гадаадын иргэн хилээр нэвтрэхэд тавих шаардлага, нөхцлийг анх тодорхойлжээ.⁵

Ваттелийн үзлээр, гадаадын иргэний харъяалсан улс нь түүний өмч хөрөнгөд ч хамаарах бөгөөд үүний үр дүнд гадаадын иргэний эрх болон өмчийн эрхийг зөрчих нь харъяалсан улсын эрхийг зөрчсөний нэгэн адилаар тооцогдох юм.⁶ Тийм ч учраас дипломат хамгаалалт эдлэх олон улсын эрх зүйн үндсэн зарчимд хөтөлсөн байна.⁷

Нэхэмжлэлийг дипломат аргаар, эсхүл албадан шийдвэрлэхэд улс *ad hoc* зөвлөлийг, хүлээн авагч улсын үйл ажиллагаатай холбогдон гадаадын иргэн болон түүний өмчид хамаарах тусгай нэхэмжлэлийг

³ Хаянхярваагийн Сэлэнгэ. *Ромын эрх зүй*, (Улаанбаатар: 1999), 43-44 дэх тал. Newcombe, Paradell, *supra* note 1. 3.

⁴ Newcombe, Paradell, *supra* note 1. 3.

⁵ Emmerich D.Vattel. *Law of Nations*. Book II, chapter VIII, 100-101. Сонирхолтой нь энд Хятад болон Япон улс нь тухайн үед гадаадын иргэн хилээр нэвтрэн орж ирэхэд заавал зөвшөөрөл авсан байх шаардлага тавьдаг бол европын бүхий л улсад тухайн улсын дайсан л биш бол хэн ч хэзээ ч чөлөөтэй зорчиж болдог байсан тухай тэмдэглэжээ.

⁶ Newcombe, Paradell, *supra* note 1. 4.

⁷ *Ibid* 4.

шийдвэрлэх арбитрайн бүрэлдэхүүнийг байгуулдаг байсан тухай Эндрю Ньюкомб, Ллуис Парадэлл нар бүтээлдээ тодорхой дурьдсан байдаг.⁸ Ийнхүү маргаан шийдвэрлэх практик нь 1794 онд АНУ болон Их Британийн хооронд байгуулсан “Найрсаг харилцаа, худалдаа болон далайн тээврийн тухай” хэлэлцээрийг байгуулснаар Америкийн хувьсгалын үед аль алиныхаа иргэдийн гаргасан нэхэмжлэлийг шийдвэрлэх комисс байгуулах болсон ажээ.⁹

III. Колоничлолын үе дэх эрх зүйн зохицуулалт

Энэ үед колони улсад оруулж буй гадаадын хөрөнгө оруулалтыг хамгаалах хэрэгцээ шаардлага үндсэндээ байхгүй бөгөөд колоничлогч улсын эрх зүйн тогтолцоо эзлэгдсэн улсын нутаг дэвсгэрт шууд үйлчилж байсан гэдгээр тайлбарлагдана.¹⁰ Энэ үед гадаадын иргэдийн өмчтэй холбогдох маргааныг шийдвэрлэх гол институт нь дотоодын шүүх байв.¹¹ Тухайн үед байгуулж байсан Найрамдал, худалдаа, далайн тээврийн хэлэлцээрт гадаадын иргэн нь дотоодын шүүхэд хандах эрхийг тусгасан байсан тухай Кеннет Ж. Вандэвелде нь “Хоёр талт хөрөнгө оруулалтын хэлэлцээр-түүх, бодлого, тайлбар” хэмээх бүтээлдээ тодорхой авч үзсэн байдаг.¹²

Найрамдал, худалдаа, далайн тээврийн хэлэлцээр нь арбитрайн заалтыг тусгаж эхэлсэн бөгөөд АНУ, Их Британийн хооронд 1794 онд байгуулсан дээрх төрлийн хэлэлцээрт нэн ялангуяа хөрөнгийг хураан авснаас үүдэх маргааныг арбитрайрт шийдвэрлэх тухай зохицуулалтыг тусгасан байв.¹³ 1799-1804 оны хооронд дээрх заалтыг хэрэглэн нийт 500 орчим арбитрайн шийдвэр гарсан нь ч тэмдэглэгдэн үлджээ.¹⁴ АНУ, Их Британийн хэлэлцээр байгуулснаас нэг жилийн дараа АНУ-Испанийн хооронд мөн адил хэлэлцээрт гарын үсэг зурсан ба нэгдсэн улсын иргэд тухайн үед Испани улс Францтай хийсэн дайны улмаас хүлээсэн хохирлоо нөхөн төлүүлэхээр нэхэмжилж байв. Хоёр улсын хооронд үүсэх маргаан шийдвэрлэх арбитрайн ажиллагаа нь ч заримдаа өмчийн маргааныг шийдвэрлэхэд чиглэж байсан ба 1871-1876 оны хооронд ердөө таван жилийн хугацаанд 2000 орчим нэхэмжлэл хүлээн авч шийдвэрлэж байсан гэдгийг Кеннет Ж. Вандэвелде нь “Хоёр талт хөрөнгө оруулалтын хэлэлцээр-түүх, бодлого, тайлбар”

⁸ Ibid 4.

⁹ Ibid 7.

¹⁰ Sornarajah, *supra* note 2, 19.

¹¹ Kenneth J. Vandeveld, *Bilateral Investment Treaties: History, Policy and Interpretation*, 1st ed. (Oxford University Press, 2010), 24.

¹² Ibid 24.

¹³ Ibid 24.

¹⁴ Ibid 25.

хэмээх бүтээлээс үзэж болно.¹⁵ 1820-иод оноос эхлэн эдийн засгийн глобалчлал эхэлж, үүнтэй зэрэгцэн гадаадын хөрөнгө оруулалтын урсгал ч огцом нэмэгдэж эхэлжээ.

1840-1940 оныг хүртэлх хугацаанд гадаадын иргэд болон тэдгээрийн өмчид учруулсан хохирлоос үүдэх 60 хэргийг арбитра шийдвэрлэснийг Jan Brownlie “Олон улсын нийтийн эрх зүйн зарчмууд” бүтээлдээ дурьдсан байдаг.¹⁶ Энд үндсэндээ онцгой нэхэмжлэлийг шийдвэрлэх *ad hoc* шүүхийг байгуулж байсан бөгөөд үндэсний шүүх нь далай тэнгист гадаадын иргэдийн өмчийг булаан авсантай холбоотой маргааныг шийдвэрлэх эрхтэй байлаа.¹⁷ Дээр дурдсан дипломат хамгаалалтыг хэрэглэх, зүй бусаар ашиглахаас үүдэн 1902 онд АНУ-д дипломат ноот гардуулахдаа латин америкийн улс гүрний аливаа өр нь тэдгээрийн эсрэг зэвсэг хэрэглэх үндэслэл болохгүй байх учиртай гэдгийг илэрхийлсэн байна.¹⁸ Аргентины Гадаад хэргийн сайд Луис Драго .Энэ нь Драгогийн онолыг хөгжүүлэх үндэс суурь болсон бөгөөд 1907 онд батлагдсан Гэрээний үүргийг сэргээхэд чиглэсэн ажиллах хүчний хязгаарлалт болон хүндэтгэн үзэх тухай Гаагийн конвенцид тусгалаа олсон ба уг конвенц нь Драго Портер Конвенц хэмээн нэрлэгддэг.¹⁹ Энэхүү конвенцийн дагуу улс гүрнүүд нь арбитра нэхэмжлэл гаргахаас татгалзахаас бусдаар улсын үүргийг сэргээхийн тулд зэвсэг хэрэглэхгүй байх үүргийг хүлээжээ.

Дэлхийн 1 дүгээр дайны дараа үеэс эхлэн аливаа олон улсын гэрээнд хувь хүн шууд бие даан нэхэмжлэл гаргах боломжийг тусгаж эхэлсэн байна.²⁰

Ерөнхийдөө олон улсын худалдаа, хөрөнгө оруулалт нь 18, 19-р зуун болон 20 дугаар зууны эхэн үед колоничлолын бодлого, эрх зүйн дэглэмийн дор хөгжин цэцэглэсэн байдаг.²¹ Хамгийн чухал нь энэ үед гадаад улс буюу колони улс дахь өөрийн иргэдийн хөрөнгө, хөрөнгө оруулалтын тухайд нутаг дэвсгэрээс хальсан шүүхийн харъяаллыг хэрэглэж болох асуудлыг хэлэлцээрийн үндсэн дээр зохицуулдаг байжээ. Ийм нутаг дэвсгэрээс хальсан харъяаллын журам нь ази, ойрхи дорнодын улсуудад үйлчилж байсан ч Латин америкийн улс гүрэнд үйлчилдэггүй байсан ба энэ нь латин америкийн улсууд дипломат хамгаалалтын талаархи бүхий л хэрэг тохиолдол болон

¹⁵ Ibid 24.

¹⁶ Ian Brownlie, *Principles of Public International law*, 7th ed. (Oxford University Press, 2008).

¹⁷ Newcombe, Paradell, *supra* note 1. 7.

¹⁸ Ibid 9.

¹⁹ <https://archive.org/details/jstor-2212500> хуудаснаас конвенцийг эхээр нь үзэж болно.

²⁰ Newcombe, Paradell, *supra* note 1.

²¹ Sornarajah, *supra* note 2, 19-21

хууль тогтоомжийн эх сурвалж болдог байснаар тайлбарлагдана.²²

Колоничлолын үед гарч ирсэн бас нэгэн онол бол Калвогийн онол²³ юм. Мөн л Аргентины хуульч Карлос Калво нь энэхүү онолыг хөгжүүлсэн бөгөөд түүний үзлээр 1/ гадаадын иргэд нь хөрөнгө оруулалтыг хүлээн авагч улсын иргэдээс илүү эрхийг эдлэх ёсгүй, 2/ гадаадын иргэдийн эрх зүйн байдал нь тэдгээрийн оршин байгаа улсын эрх зүйд захирагдана, 3/ гадаадын иргэдтэй холбогдон үүсэх аливаа маргааны хувьд хүлээн авагч улсын шүүх нь онцгой харьяаллыг эдэлнэ.²⁴ Гэхдээ энэхүү онол нь олон улсын эрх зүйд зан заншлын хэм хэмжээ хэмээн хүлээн зөвшөөрөгдөж чадаагүй юм.

IV. Колоничлолын дараахь буюу 1990 он хүртэлх хөгжил

Дэлхийн 2 дугаар дайн дуусаж, ихэнх колони улсууд бие даан тусгаар тогтнож эхэлсэн 1940-1960 оны хооронд улс хоорондын бус олон улсын байгууллагууд гадаадын хөрөнгө оруулалтад хамаарах олон талт эрх зүйн зохицуулалтыг бий болгох тал дээр нэлээд шаргуу ажиллаж эхэлжээ. 1949 онд Олон улсын худалдааны танхимаас Гадаадын хөрөнгө оруулалтад шударгаар хандах тухай олон улсын кодекс"-ийн /ICC Code/ төслийг боловсруулсан боловч энэ нь батлагдаж чадаагүй юм. Уг баримт бичигт гадаадын хөрөнгө оруулалтыг хамгаалах, шударга тэгш хандах, ашиг орлого гуйвуулахад хориг тавих явдлыг цэглэх, хөрөнгийг хураан авсан үед шударга нөхөн төлбөр олгох зэргээс гадна улс-улсын хооронд хөрөнгө оруулалтын талаар үүсэх маргааныг тус танхимын арбитра шийдвэрлэх нөхцлийг тусгасан байлаа.²⁵

Үүний дараа Олон улсын эрх зүйн холбооноос /International Law Association/ Гадаадын хөрөнгө оруулалт ба гадаадын хөрөнгө оруулалтын шүүхэд хамаарах арбитра шүүхийн загвар дүрэм-ийг боловсруулав. Мэдээж гадаадын хөрөнгө оруулалтад хамаарах аливаа дэглэмийн тухай зохицуулалтаас илүүтэй маргаан хянан шийдвэрлэхэд хамаарах зохицуулалтыг агуулсан ч энэ дүрэм батлагдаж чадаагүй юм.

Түүхээс үзэхэд Дэлхийн 2 дугаар дайны дараа гадаадын хөрөнгө оруулалтын маргааныг арбитраар шийдвэрлүүлэх нь эрс нэмэгдэж эхэлжээ.²⁶ Гэхдээ хөгжиж буй орнуудын дийлэнх нь арбитра үл итгэх хандлагатай байсан бол гадаадын хөрөнгө оруулагчид нь хөндлөнгийн

²² Newcombe, Paradell, *supra* note 1. 9.

²³ Sornarajah, *supra* note 2, 220-221.

²⁴ Newcombe, Paradell, *supra* note 1.

²⁵ International Chamber of Commerce, <https://iccwbo.org/global-issues-trends/trade-investment/investment/>.

²⁶ Newcombe, Paradell, *supra* note 1. 24.

нөлөө, авилгал, үр дүн муутай байдал зэргээр шалтаглан үндэсний шүүхэд хандахаас зайлсхийж байлаа. Тийм ч учраас арбитрын заалт бүхий хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах зохицуулалтыг өргөнөөр хэрэглэж эхэлсэн юм.²⁷ Ихэнх олон улсын арбитр нь газрын тосны салбар дахь хөрөнгө оруулалтад хамаарах зөвшөөрлийг цуцалсан буюу нийгэмчилсэн асуудлаас үүдэх маргааныг харьяалан шийдвэрлэж байсан тухай Andrew Newcombe, Lluís Paradell нар бүтээлдээ дурджээ.²⁸

1965 онд Дэлхийн Банкны дэмжлэгтэйгээр Улс ба бусад улсын иргэдийн хооронд хөрөнгө оруулалтын талаарх маргааныг шийдвэрлэх тухай Вашингтоны конвенцыг баталсан явдал нь хөрөнгө оруулалтын маргааны харьяаллын талаар тусгагдсан гол олон улсын олон талт гэрээ болсон ба өдгөө хамгийн амжилттай хэрэгжиж яваа гэрээний нэг юм.

Олон улсын хөрөнгө оруулалтын маргааныг харьяалахтай холбогдон зайлшгүй дурьдах ёстой байгууллага бол Олон улсын шүүх юм. 1959 оноос эхлэн байгуулагдсан Хөрөнгө оруулалтын хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай хэлэлцээр нь гагцхүү хэлэлцээрт оролцогч улсын хооронд үүсэх маргааныг талууд харилцан тохиролцсон бол олон улсын шүүхэд шийдвэрлүүлэх тухай зохицуулалтыг тусгадаг байсан ба хэрэв тохиролцоонд хүрээгүй бол аль нэг талын хүсэлтээр арбитрт шийдвэрлүүлдэг байв. Олон улсын шүүх нь хэдийгээр 1945 онд байгуулагдсан ч хөрөнгө оруулалтад холбогдох ердөө зургаан маргааныг шийдвэрлэсэн баримт бий.²⁹ Эдгээрээс гурав нь харьяаллын бус маргаан хэмээн буцаагджээ. 1968 он хүртэл Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай хэлэлцээр нь гагцхүү дээрх төрлийн маргаан шийдвэрлэх зохицуулалтыг агуулдаг байсан бол хамгийн анх 1968 онд Индонез-Нидерландын хооронд байгуулсан хэлэлцээрт хөрөнгө оруулагч-хүлээн авагч улсын хоорондын маргаан шийдвэрлэх тухай зохицуулалтыг тусгаж өгснөөр хөрөнгө оруулалтын маргаан шийдвэрлэх харьяаллын зохицуулалтын шинэ төрөл бий болсон гэж болох юм.³⁰ Үүний дараа 1969 онд Олон улсын хөрөнгө оруулалтын

²⁷ Ibid 24.

²⁸ Ibid 24.

²⁹ Ibid 35.

³⁰ <http://investmentpolicyhub.unctad.org/IIA/CountryBits/148#iiaInnerMenu>. Энэхүү хэлэлцээр нь өдгөө хүчин төгөлдөр бус болсон бөгөөд хөрөнгө оруулагч-хүлээн авагч улсын хооронд үүсэх маргааныг 1965 оны Вашингтоны конвенцийн дагуу шийдвэрлүүлж болох тухай товчхон зохицуулалтыг тусгаж өгчээ: Article 11 “The Contracting Party in the territory of which a national of the other Contracting Party makes or intends to make an investment, shall assent to any demand on the part of such national and any such national shall comply with any request of the former Contracting Party, to submit, for conciliation or arbitration, to the Centre established

маргаан шийдвэрлэх төвөөс Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай хэлэлцээрийн маргаан шийдвэрлэх зохицуулалтад хэрэглэж болох загвар заалтуудын эмхтгэлийг бэлтгэн хэвлүүлжээ.³¹ Гэхдээ ихэнх ном зохиолд Чад-Италийн хооронд 1969 онд байгуулсан Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай хэлэлцээрт л хөрөнгө оруулагч-улсын хооронд үүсэх маргааныг арбитраж харъяалан шийдвэрлүүлэх тухай зохицуулалт жинхэнэ ёсоор тусгагдсан хэмээн үздэг.³² 1970-1980 онд тийм ч олон хоёр талт хэлэлцээр байгуулагдаагүй бөгөөд 1987 он гэхэд 265 ийм хэлэлцээр байгуулсны дийлэнх нь хөгжингүй болон хөгжиж буй улсын хооронд байгуулагдсан байлаа.

V. 1990-2010 оны хөгжлийн онцлог

1990-ээд оноос эхэлсэн улс төрийн тогтолцооны шинэчлэл нь олон улсын хөрөнгө оруулалтын эрх зүйд ч ихээхэн нөлөө үзүүлсэн хэлж болно. Нэн ялангуяа социалист системээс татгалзаж, чөлөөт зах зээлийн эдийн засгийг сонгох болсон олон улс гүрэн гадаадын хөрөнгө оруулалтыг эрчимтэй татах бодлогыг баримталж эхэлсэн бөгөөд энэ зорилгоо хэрэгжүүлэх үүднээс олон талт болон хоёр талт хөрөнгө оруулалтын хэлэлцээрийг олноор байгуулах буюу нэгдэн орж эхэлсэн билээ. Энэ үед хамаарах Хөрөнгө оруулалтыг хамгаалах хэлэлцээрийн бүтэц, зохицуулалт нь нэг жигд, товчхон бөгөөд гол төлөв хөрөнгө оруулагчийн эрхийг хамгаалах гол зорилготой байв. Дийлэнх хэлэлцээрт хөрөнгө оруулалт ба хөрөнгө оруулагчийг тодорхойлох хамгийн энгийн, ерөнхий тодорхойлолтыг хэрэглэж, маргаан үүссэн үед гол төлөв олон улсын арбитраж хандан шийдвэрлүүлэх өргөн боломжийг олгосон зохицуулалтыг тусгасан. Монгол Улс ч 1990 оноос эхлэн уг хэлэлцээрийг бусад улс оронтой байгуулж эхэлсэн ба социалист системд байсан бусад улсын нэгэн адил гадаадын хөрөнгө оруулалтыг татаж, эдийн засгийн хөгжлийг түргэтгэх бодлогыг баримталж байсан юм.

Энэ үеэс ч урьд өмнө байгуулсан хөрөнгө оруулалтын гэрээнээс үүдэх маргаан арбитраж анх шийдвэрлэгдэж эхэлсэн тухай судлаачид бүтээлдээ тэмдэглэсэн байдаг.³³ Олон улсын хөрөнгө оруулалтын маргаан хянан шийдвэрлэх төв 1965 оны Вашингтоны конвенцийн үндсэн дээр байгуулагдсанаас хойш анх 1972 онд эхний маргаанаа

by the Convention of Washington of March 18, 1965, 1 any dispute that may arise in connection with the investment”.

³¹ International Centre for Settlement of Investment Disputes, ICSID Model Clauses, <http://icsidfiles.worldbank.org/icsid/icsid/staticfiles/model-clauses-en/main-eng.htm>.

³² Newcombe, Paradell, *supra* note 1. 45.

³³ Ibid 58.

бүртгэж авсан³⁴ бол улс-хөрөнгө оруулагчийн хооронд байгуулсан гэрээнээс үүдэх маргаан анх 1990 онд Asian Agricultural Products Ltd болон Шри Ланка улсын хооронд үүсчээ.³⁵ Нэгэнт улс хооронд байгуулах Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах хэлэлцээр болон бусад олон улсын хөрөнгө оруулалтын гэрээнд маргаан шийдвэрлэх арбитрын заалтыг тусгах нь түгээмэл болсон ба 1972 оноос хойш өнөөдрийг хүртэл олон улсын арбитуудад 1061 маргаан бүртгэж, шийдвэрлэгдсэн буюу шийдвэрлэх ажиллагаа явагдаж байна.³⁶

VI. 2010- өнөөг хүртэл буюу бууралт, шинэчлэлтийн үе

2009 оныг хүртэл жил 200 орчим тоогоор байгуулагдаж байсан Хөрөнгө оруулалтыг хамгаалах хэлэлцээр 2010 оноос огцом буурч эхлэв. 2010 онд 56, 2011 онд 50, 2012 онд 37, 2013 онд 48, 2014 онд 40, 2015 онд 42, 2016 онд 43, 2017 онд 39, 2018 онд 43, 2019 онд 21, 2020 онд дөнгөж 6 хэлэлцээр³⁷ шинээр байгуулагдсан нь өмнөх үеүдээс огцом буурсныг илэрхий харуулж байна. Түүнчлэн, 2010 оноос эхлэн олон улсын хөрөнгө оруулалтын эрх зүйд ажиглагдсан нэг үзэгдэл бол 1990-ээд онд болон түүнээс өмнө байгуулсан хөрөнгө оруулалтыг хамгаалах хэлэлцээрийг олноор цуцалж эхэлсэн явдал юм. 2010-2018 оныг хүртэлх хугацаанд нийтдээ 187 хэлэлцээрийг цуцалсан ба энд, Энэтхэг, Индонез улсууд голлох үүргийг гүйцэтгэсэн.³⁸ Тухайлбал, Энэтхэг улс нь нийт 86 улстай Хөрөнгө оруулалтыг хамгаалах хэлэлцээр байгуулснаас 64 хэлэлцээрийг нэг талын санаачлагаар цуцалсны тоонд 2001 оны 1 сарын 3-ны өдөр Монгол Улстай байгуулсан хэлэлцээр ч багтаж байгаа юм. Ийнхүү цуцалж, шинээр хэлэлцээр байгуулах болсон шалтгаан нь ч гол төлөв төр-хөрөнгө оруулагчийн хоорондын маргааныг хянан шийдвэрлэх эрх зүйн зохицуулалтаас үүдэлтэй. Улс гүрнүүд 2010-аад оны үеэс эхлэн төр-хөрөнгө оруулагчийн хооронд үүсэх маргааныг хянан шийдвэрлэх асуудлыг шинэчлэх, боловсронгуй болгох асуудалд эрчимтэй анхаарал хандуулж эхэлсэн ба энэ ч үүднээс, тус бүр

³⁴ Holiday Inns S.A. and others v. Morocco, ICSID Case No. ARB/72/1, <http://www.italaw.com/cases/3391>

³⁵ Asian Agricultural Products Ltd. (AAPL) v. Republic of Sri Lanka, ICSID Case No. ARB/87/3, <http://www.italaw.com/cases/96>.

³⁶ United Nations Conference on Trade and Development, <http://investmentpolicyhub.unctad.org/ISDS?status=1000>.

³⁷ НҮБ-ийн Худалдаа хөгжлийн бага хурлаас эрхлэн хөтөлдөг хөрөнгө оруулалтын мэдээллийн цахим хуудаснаас үзэж болно: <https://investmentpolicy.unctad.org/international-investment-agreements>.

³⁸ НҮБ-ийн Худалдаа хөгжлийн бага хурлаас эрхлэн хөтөлдөг хөрөнгө оруулалтын мэдээллийн цахим хуудаснаас дараахь холбоосоор үзэж болно: <https://investmentpolicy.unctad.org/international-investment-agreements:India>.

Хөрөнгө оруулалтыг хамгаалах хэлэлцээрийн загвараа шинээр боловсруулж, ийнхүү боловсруулсан шинэ загвараа үндэслэсэн шинэ хэлэлцээр байгуулахыг эрмэлзэх болсон юм. Нийтэд ил 80 гаруй загвар хэлэлцээрээс 20 орчим нь 2010 оноос хойш боловсруулсан ба эдгээрийг задлан судалж үзэхэд 2015 оноос хойших загварууд нь илүү нарийн зохицуулалтыг агуулсан, төр-хөрөнгө оруулагчийн эрх үүргийн тэнцвэрийг хадгалахыг зорьсон байна. Тухайлбал, Бельги-Люксембургийн Эдийн засгийн холбооны Загвар хэлэлцээрийн 3 дугаар бүлэг “Хөрөнгө оруулалт ба тогтвортой хөгжил” хэмээх нэртэй бөгөөд энд хөдөлмөрийн стандарт, хүрээлэн буй орчны стандарт, корпорацийн нийгмийн хариуцлагын үүргийг тусгажээ.³⁹ Дийлэнх шинэ загварт, хөрөнгө оруулалт, хөрөнгө оруулагчийн тодорхойлолтыг илүү нарийвчилж, оффшор бүсэд татвараас зугтах замаар хөрөнгө оруулалт хийх боломжийг хязгаарлахаар “Denial of Benefits” буюу хэлэлцээрийн нэг талын харьяат боловч өөр бусад гуравдагч улсын харьяатын хяналтад байгаа үед хэлэлцээрийн дагуу давуу хөнгөлөлтийг огт эдлэхгүй байх, хэлэлцээрийг үндэслэн маргаан үүсгэх эрхгүй байхаар зохицуулсан байна.⁴⁰

Сүүлийн жилүүдэд шинээр байгуулагдсан хэлэлцээрийн нэлээд нь төр-хөрөнгө оруулагчийн хоорондын маргаан шийдвэрлэх эрх зүйн зохицуулалтад шинэчлэлт хийсэн тухай НҮБ-ын Худалдаа хөгжлийн бага хурлын 2019 оны 7 сарын 19-ны өдрийн тайланд дурджээ.⁴¹ Түүнээс хойш, 2020-2024 оныг хүртэлх хугацаанд хийсэн хэлэлцээрийн 57 хувьд нь тусгагдсан төр-хөрөнгө оруулагчийн хоорондын маргаан шийдвэрлэх зохицуулалтыг тусгасан ба үлдсэн 43 хувь нь ийм зохицуулалтыг тусгаагүй⁴² нь ихээхэн сонирхол татна.

Саяхныг хүртэл олон улсын хөрөнгө оруулалтын маргаан хянан шийдвэрлэх хамгийн боломжит хувилбар бол олон улсын арбитраж юм гэсэн үзэл хүчтэй ноёрхож байсан ч нэн ялангуяа АНУ-Европын Холбооны улсын хооронд байгуулахаар хэлэлцэж байсан Транс Атлантын Худалдаа, Хөрөнгө оруулалтын түншлэлийн хэлэлцээрээс үүдэн /ТТИР/ арбитраас татгалзах, арбитрын ил тод байдлын талаар шүүн хэлэлцэх нь элбэг болжээ. ХБНГУ-ын судлаач Henning Klodt-

³⁹ <https://investmentpolicy.unctad.org/international-investment-agreements/treatyfiles/5854/download> холбоосоор энэ загварыг үзнэ үү.

⁴⁰ НҮБ-ын Худалдаа хөгжлийн бага хурлын <https://investmentpolicy.unctad.org> хуудаснаас нийтэд ил бүхий л загвар хэлэлцээрээс ийм зохицуулалтыг үзэж болохоор байна. Нийт 19 загвар хэлэлцээр 2010 оноос хойш боловсруулагдсан ба зарим улс нь төрийн бодлогын нууцад хамааруулдаг учир нийтэд ил болгоогүй байна.

⁴¹ United Nations Conference on Trade and Development (UNCTAD), Taking Stock of IIA Reform: Recent Developments, July 19, 2019, 3.

⁴² United Nations Conference on Trade and Development (UNCTAD), The Reform of International Investment Agreements – State of Play, No. 3 (2025), 1.

ийн “Transparenz verbessern, Missbrauch erschweren” өгүүллээс⁴³ үзэхэд арбитрт хөрөнгө оруулагч-улсын хооронд үүсэх маргааныг шууд харьяалан шийдвэрлэх нь учир дутагдалтай бөгөөд хөрөнгө оруулагч улсын үндэсний шүүхэд хянан шийдвэрлэх боломжийг илүү давуу тусгах нь зүйтэй гэсэн санааг илэрхийлсэн байдаг. Энэ үзэл санаа хүчтэй ноёрхож байгаагийн илрэл нь 2016 оны 6 сард Европын холбооны шүүх нь Европын холбооны улс болон Канад улсын хооронд байгуулсан Эдийн засаг, худалдааны дэлгэрэнгүй хэлэлцээрт (СЕТА)⁴⁴ заасан “Олон улсын хөрөнгө оруулалтын шүүх”-ийг байгуулахаар эцэслэн тохирсон явдал юм.⁴⁵ Гэхдээ одоогоор уг шүүх эцэслэн байгуулагдаж, үйл ажиллагаандаа ороогүй ба ийм шүүх байх эсэх талаар ч хуульчдын үзэл бодол зөрчилдөөнтэй хэвээр байна.

2018 онд шинээр байгуулагдсан зарим хөрөнгө оруулалтыг хамгаалах хэлэлцээр, тухайлбал, Бразил улсаас Энэтхэг (2020), Эквадор (2019), Морокко (2019), АНЭУ (2019) улсуудтай байгуулсан хэлэлцээрт хөрөнгө оруулагч-төрийн хооронд үүсэх маргааныг арбитраар шийдвэрлүүлэх заалтыг огт тусгаагүй байна. Зарим улс олон улсын арбитрт хандах нөхцөл боломжийг нэлээд хязгаарлах, тухайлбал урьдчилсан шалгуур тавих зэргээр тохиролцож эхэлжээ.

Өөр нэгэн сонирхолтой жишиг ажиглагдаж эхэлсэн нь, хэлэлцээрийг 2 улс бус, харин бүс нутгийн олон улсын байгууллагын хүрээнд байгуулж эхэлсэн явдал байв. Европын холбоо, АСЕАН, Өмнөд Африкийн Хөгжлийн Нийгэмлэг (SADC) зэрэг бүс нутгийн олон улсын нэгдлүүд нь өөр хоорондоо бүсийн хэмжээнд, эсхүл хамтран аль нэг улстай 2 талт, нөгөө талаар олон талт ч гэж хэлж болохуйц хэлэлцээрийг байгуулж эхэлсэн юм. Жишээ нь, Япон-Европын холбооны улсын хооронд 2018 оны 7 сарын 17-нд Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр⁴⁶, Сингапур-Европын холбоо хооронд 2018 оны 10 сарын 15-нд Хөрөнгө оруулалтыг хамгаалах хэлэлцээр⁴⁷, 2019 оны 3 сарын 15-нд Карифорумын улсууд буюу ИБУИНВУ болон Антигуа Барбуда, Багам, Барбадос, Белиз, Доминика, БНДУ, Гренада зэрэг 14 улстай байгуулсан Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр⁴⁸,

⁴³ Henning Klodt, Transparenz verbessern, Missbrauch erschweren. Wirtschaftsdienst Nr. 7, 2014, S. 459.

⁴⁴ <http://ec.europa.eu/trade/policy/in-focus/ceta/ceta-chapter-by-chapter/>

⁴⁵ <http://trade.ec.europa.eu/doclib/press/index.cfm?id=1608>

⁴⁶ Энэ хэлэлцээр нь 2019 оны 2 сарын 1-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болсон ба 8.6-8.13 дахь хэсэгт хөрөнгө оруулалтад хамаарах үндсэн зохицуулалт, 21 дүгээр бүлэгт маргаан шийдвэрлэх зохицуулалт тусгагдсан байна.

⁴⁷ 2018 оны 10 сарын 15-нд байгуулсан тус хэлэлцээр одоогоор хүчин төгөлдөр болоогүй байна. Урьд өмнөхөөс маш өргөн дэлгэрэнгүй зохицуулалттай бөгөөд ЕХ-ноос цаашид баримтлах загвар гэж хэлж болохуйц хэлэлцээр гэж үзэж байна.

⁴⁸ 2019 оны 3 сарын 15-ны өдөр байгуулагдсан тус хэлэлцээр нь одоогоор хүчин төгөлдөр болоогүй бөгөөд 60-79 дүгээр зүйлд хөрөнгө оруулалтад хамаарах эрх

АСЕАН-ын Бүс нутгийн эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр 2020 оны 11 сарын 15-нд⁴⁹ тус тус байгуулагджээ. Харин Европын холбооны улсын хувьд 2020 оны 5 сарын 5-ны өдөр, 23 гишүүн улс хооронд урьд өмнө байгуулсан бүхий л хөрөнгө оруулалтыг хамгаалах хэлэлцээрийг бүхэлд нь цуцлах гэрээнд гарын үсэг зурсан⁵⁰ ба цаашид уг харилцааг хэрхэн зохицуулах нь ихээхэн сонирхол татаж байгаа юм.

2018 оноос хойш Хөрөнгө оруулалтын хэлэлцээр байгуулж буй талууд нь төр-хөрөнгө оруулагчийн хооронд маргаан үүссэн үед аль нэг олон улсын арбитраг хандах бус, харин талууд дундаасаа байгуулсан маргаан шийдвэрлэх шүүхэд хандахаар тусгаж байгаа явдал юм. Жишээ нь, Сингапур-Европын холбооны улсын хооронд байгуулсан Хөрөнгө оруулалтыг хамгаалах хэлэлцээрийн 3.9.2-т зааснаар:

а/ Европын холбооны улс 2 гишүүн,

б/ Сингапур улс 2 гишүүн,

с/ Европын холбоо болон Сингапур улс хамтран тус тусын алиных нь ч иргэн бус 2 гишүүнийг арбитрагын шүүхийн гишүүнд санал болгон 8 жилийн хугацаагаар томилох ба маргаан үүссэн үед, эдгээр гишүүдээс сонгон маргаан шийдвэрлэхээр зохицуулсан байна. Үүнээс үзэхэд зарим улсууд олон улсын арбитраас татгалзах хандлагыг баримталж байгаа нь илтэд харагдаж байгаа юм.

Түүнээс гадна, НҮБ-ын Олон улсын худалдааны эрх зүйн комисс нь 2017 онд Хөрөнгө оруулалтын маргаан шийдвэрлэх ажиллагааг боловсронгуй болгох зорилгоор “3 дугааражлын хэсэг”-ийг байгуулсан бөгөөд жил бүр 3-4 удаагийн хэлэлцүүлэг хийж улс орнууд үзэл баримтлалаа илэрхийлж, олон улсын хөрөнгө оруулалтын маргаан шийдвэрлэх эрх зүйн зохицуулалтын хөгжилд томоохон шинэчлэлт хийх магадлалыг бий болгосон бөгөөд олон улсын арбитраас олон талт хөрөнгө оруулалтын шүүх рүү чиглэх суурь тавигдлаа хэмээн зарим судлаачид үзэж байна.⁵¹ Уг ажлын хэсгийн үйл ажиллагааны үр

зүйн зохицуулалтыг тусгасан байна.

⁴⁹ 2020 оны 11 сарын 15-нд байгуулсан тус хэлэлцээрт Австрали, БНХАУ, Япон, БНСУ, Шинэ Зеланд улсууд оролцсон ба одоогоор хараахан хүчин төгөлдөр болоогүй байна. Тус хэлэлцээрийн 10 дугаар бүлэг нь бүхэлдээ хөрөнгө оруулалтад хамаарах эрх зүйн зохицуулалтыг агуулсан ба харин маргаан шийдвэрлэх зохицуулалтыг хэлэлцээрийн хувьд бүхэлд нь хамаарах байдлаар 19 дүгээр зүйлд тусгажээ.

⁵⁰ <https://www.iisd.org/itn/en/2020/06/20/eu-member-states-sign-agreement-to-terminate-intra-eu-bits-while-german-investor-brings-claim-against-the-netherlands-under-the-ect/>

⁵¹ Marc Bungenberg, August Reinisch. *From Bilateral Arbitral Tribunals and Investment Courts to a Multilateral Investment Court. Options regarding the Institutionalization of*

дүнд, арбитражын ёс зүйн дүрэм, арбитражын шийдвэрийг давж заалдах механизмыг бий болгох эхний төслүүд хэлэлцэгдэж байна.

Дүгнэлт

Дээрх бүхнийг нэгтгэн дүгнэж үзэхэд олон улсын хөрөнгө оруулалтын эрх зүй нь 2010 оноос хойш зохицуулалтын хувьд нэлээд өвөрмөц байдлаар өөрчлөгдөн хөгжиж байна. Энэ нь, хөрөнгө оруулалтыг хамгаалах хэлэлцээрийн огцом бууралт, цуцлалтаар илрэхээс гадна шинээр байгуулж буй хэлэлцээрт агуулагдах зохицуулалтаас илэрхий харагдах болжээ. Үндсэндээ, хөрөнгө оруулалтыг хамгаалах бодлогоос хөрөнгө оруулалт болон хөрөнгө оруулалтыг хүлээн авагч улсын эрх ашгийг эн тэнцүү хангах бодлогод чиглэж, олон улсын арбитраас-дундын буюу олон улсын олон талт шүүх гэсэн чиглэл рүү явж буй нь тодорхой болж байна. Гэхдээ энэ нь, олон улсын хөрөнгө оруулалтын эрх зүйд арбитражын ач холбогдол буурна гэж шууд хэлэхгүй бөгөөд хүчин төгөлдөр үйлчилж буй Хөрөнгө оруулалтыг хамгаалах олон зуун хэлэлцээрийн хүрээнд ач холбогдолтой хэвээр байх юм. Түүнчлэн, дан ганц хөгжиж буй болон буурай хөгжилтэй улсууд ч биш өндөр хөгжилтэй улс гүрнүүд гадаадын хөрөнгө оруулалтаас үүдэн маргаан үүсэхээс урьдчилан сэргийлэх бодлогыг ч чухалчлах болсон байна. Энэхүү чиг хандлага, өөрчлөлтийг сайтар анхааран судалж, түүнтэй зохицох хөрөнгө оруулалтын эрх зүйн зохицуулалт, бодлогыг онол, практикийн судалгааны үндсэн дээр боловсруулан хэрэгжүүлэх нь эрх зүй болон эдийн засгийн чухал ач холбогдолтой гэдгийг эцэст нь тэмдэглэж байна.

[Ном зүй]

- Хаянхярваагийн Сэлэнгэ. Ромын эрх зүй, Улаанбаатар: 1999.
- Andrew Newcombe, Lluís Paradell, *Law and Practice of Investment Treaties*, Kluwer Law International, 2009.
- Comprehensive Economic and Trade Agreement (CETA), European Union – Canada, 2016.
- Convention on the Settlement of Investment Disputes between States and Nationals of Other States (ICSID Convention), Washington D.C., 1965.
- Emmerich de Vattel, *The Law of Nations (Le Droit des gens)*, 1758 (орчин үеийн хэвлэл ашигласан).
- Hague Convention Respecting the Limitation of the Employment of Force for Recovery of Contract Debts (Drago–Porter Convention), 1907.
- Henning Klodt, *Transparenz verbessern, Missbrauch erschweren*, Wirtschaftsdienst Nr. 7, 2014.
- Hugo Grotius, *De Jure Belli ac Pacis*, 1625, (орчин үеийн хэвлэл ашигласан).
- Ian Brownlie, *Principles of Public International Law*, 7th ed. Oxford University Press, 2008.
- International Chamber of Commerce, *Draft International Code of Fair Treatment for Foreign Investment*, 1949.
- International Law Association, *Draft Convention on the Settlement of Investment Disputes*.
- Kenneth J. Vandeveld, *Bilateral Investment Treaties: History, Policy and Interpretation*, 1st ed. Oxford University Press, 2010.
- Muthucumarawamay Sornarajah, *The International Law on Foreign Investment*, Cambridge, 2010.
- Marc Bungenberg, August Reinisch. *From Bilateral Arbitral Tribunals and Investment Courts to a Multilateral Investment Court. Options regarding the Institutionalization of Investor-State Dispute Settlement*, 2nd ed. Springer Open, 2019.
- Transatlantic Trade and Investment Partnership (TTIP). (эцэслэн байгуулагдаагүй).
- Treaty of Amity, Commerce and Navigation (Jay Treaty), United States – Great Britain, 1794.
- United Nations Conference on Trade and Development (UNCTAD), *World Investment Report*, 2019.
- United Nations Conference on Trade and Development (UNCTAD), *Taking Stock of IIA Reform: Recent Developments*, July 19, 2019.
- United Nations Conference on Trade and Development (UNCTAD), *The Reform of International Investment Agreements – State of Play*, No. 3 (2025).

[Abstract]

**History and Development Tendency
of International Investment Law**

Baigal Enkh-Amgalan

Doctor of Laws (Ph.D.).

Associate Professor of Private Law Department

School of Law, National University of Mongolia

Ulaanbaatar, Mongolia

Since the early 2000s, international investment law has emerged as one of the most rapidly developing fields of law. Scholarly literature has traditionally periodized the development of international investment law into such stages as the ancient and medieval era, and the pre- and post-colonial periods. However, this conventional classification no longer adequately reflects contemporary developments. Following the earlier distinction between the pre- and post-World War II periods, the collapse of the socialist system gave rise to a phase commonly characterized by post-socialist transition and globalization, while since the 2010s a further phase of structural reform in international investment law has been underway. This article argues for a revised periodization of the historical development of international investment law and advances a new analytical framework for understanding its evolution.

[Keywords]

Investment Law, International Investment Law, Investment Protection Agreements, Evolution of Investment Law, Contemporary Trends in International Investment Law.